**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,**
**ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН**
**ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 25 өдөр Дугаар 655 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсэг-413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон, нийт 3,765,510.00 (гурван сая долоон зуун жаран таван мянга таван зуун арван) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашины (мотоцикл, трактор) 2 дахь удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй тул акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, бригадын генерал Ц.Амгаланбаяр болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Б.ГАВАА

0002727

D:\Huraldaanii material\2018 on\2018.12.25\Togtool.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн
655 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ХЭСЭГ-413 ДУГААР НЭЭЛТТЭЙ, ХААЛТТАЙ ХОРИХ АНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ АВТОМАШИН (мотоцикл, трактор)

| Д/д | Автомашины нэр, улсын бүртгэл, арлын, хөдөлгүүрийн дугаар | Ашиглалтад орсон он | Нийт гүйлт (км) | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэгдэл өртөг (төгрөг) | Сэлбэгээр худалдсанаас олох орлогын доод хэмжээ үнэ (төгрөг) |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мотоцикл 06-66 СЭЗ (арал-LVHBCcKC70K008889) | 2004 | 100000 | 1,263,510.00 | 1,263,510.00 | | 50,000.00 |
| 2 | Трактор, 36-26 СБ | 2009 | 450000 | 2,502,000.00 | 2,502,000.00 | | 250,000.00 |
| | Нийт дүн | | | 3,765,510.00 | 3,765,510.00 | - | 300,000.00 (гурван зуун мянган) |